



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 5/37

Ховд

Ч.Түмэндэмбэрэлийг ажилд  
томилох тухай


Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 86 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05/13440 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Чойнямын Түмэндэмбэрэлийг 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн аймгийн Биеийн тамир, спортын газрын даргаар томилсугай.

2. Ч.Түмэндэмбэрэлд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-10-5 дахь шатлал буюу 1088657 төгрөг /нэг сая наян найман мянга зургаан зуун тавин долоо/-өөр цалинжуулж, хууль тогтоомжид заагдсан холбогдох нэмэгдлүүдийг сар бүр бодож олгохыг Биеийн тамир, спортын газрын нягтлан бодогч /О.Пүрэвсүх/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Ч.Түмэндэмбэрэлд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ